



## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

### Хоёр долоо хоног тутмын мэдээ №17

#### Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2022 оны 09-р сарын 15 наас 10-р сарын 12 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

#### Хоёр. Шувууны томуугийн хүний өвчлөлийн олон улсын мэдээлэл:

2022 оны 09-р сарын 15 наас 10-р сарын 12 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6, H3N8, H7N9, H9N2, H7N4, H5N8, H10N3 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

2022 оны 09-р сарын 15 наас 10-р сарын 12 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 өндөр хоруу вирусн хэвшинжээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 1 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Испани улсын Гвадалахара хотод амьдардаг 19 настай эрэгтэйд өвчний шинж тэмдэг илэрч 9-р сарын 17 нд эмнэлэгт хандсан. Шинж тэмдэг илрэхээс өмнө тахиа шувууны аж ахуйд ажиллаж байсан.

#### Гурав. 2022 оны 09-р сарын 15 наас 10-р сарын 12 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувуудын мэдээлэл:

2022 оны 09-р сарын 15 наас 10-р сарын 12 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Франц, Канада, Герман, Ирланд, Дани, Испани, Филиппин, Их Британи, Бельги, АНУ, Өмнөд Африк, ОХУ, Португал, Итали, Алжир, Голланд, Япон, Норвеги, Нигер, Польш зэрэг 20 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 143 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс тэжээвэр шувуудын аж ахуйд 62, махчин болон нүүдлийн шувууд 79, үнэг 1, оцон шувуу 1 өвчилсөн тохиолдол бүртгэгдсэн. (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу).


(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

№	Хэлбэр	Улс	Зүйлийн нэр	Тохиолдын тоо	Аж ахуйн хэлбэр
1	H5N1	Алжир	Тодорхойгүй	1	Шувууны аж ахуй
2	H5N1	Бельги	Галуу, хун, нугас, тахиа	14	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
3	H5N1	Дани	Гургуул	3	Зэрлэг шувуу
4	H5N1	Франц	Цахлай, хун, дэглий, тахиа	27	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
5	H5N1	Герман	Тахиа, цацагт хяруул, цахлай	15	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
6	H5N1	Ирланд	Үнэг, Morus bassanus	25	Зэрлэг шувуу, хөхтөн амьтан
7	H5N1	Итали	Ногоохон нугас, зэрлэг нугас, тахиа	2	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
8	H5N1	Япон	Эгэл шонхор	1	Махчин шувуу
9	H5N1	Голланд	Гургуул, тахиа	15	Шувууны аж ахуй
10	H5N1	Нигер	Тодорхойгүй	3	Шувууны аж ахуй

11	H5N1, H5N5	Норвеги	Хүрэн толгойт цахлай	2	Нүүдлийн шувууд
12		Филлипин	Тодорхойгүй	1	Шувууны аж ахуй
13	H5N1	Польш	Тодорхойгүй	1	Шувууны аж ахуй
14	H5N1	Португал	Morus bassanus, Цацагт хяруул	4	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
15	H5N1	ОХУ	Тодорхойгүй	2	Шувууны аж ахуй
16	H5N1	Өмнөд Африк	Оцон шувуу, тахиа	4	Шувууны аж ахуй, нүүдлийн шувууд
17	H5N1	Испани	Шилийн сар, Morus bassanus	3	Махчин шувуу, нүүдлийн шувууд
18	H5N1	Их Британи	Цагаан сүүлт бүргэд, Morus bassanus, тахиа	8	Махчин шувуу, нүүдлийн шувууд, Шувууны аж ахуй
19	H5N1	АНУ	Цацагт хяруул, тахиа, бор шувууд, нугас, тас	12	Махчин шувуу, нүүдлийн шувууд, Шувууны аж ахуй
20	H5N1	Канад	Цахлай	1	Нүүдлийн шувуу

Эх сурвалж: *Oie.int, Cidrap.umn.edu*

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

*Шувууны томуу хариуцсан баг*